



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ ХЭВЭЭР БАЙНА.

Аудитын код: УАГ-НАГ-2019/01/-НА

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг
2019 оны 04 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020

Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор:

Б.Уранбилэг

Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар _____	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй _____	3
БҮЛЭГ 1 ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН СИСТЕМД УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУД БҮРЭН ХАМРАГДСАН Ч ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН ОРУУЛАХ АЖИЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА. _____	5
БҮЛЭГ 2 ХУУЛИЙН 3.1.4¹, 3.1.5²-Д ХАМААРАХ БАЙГУУЛЛАГУУД “ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА _	9
БҮЛЭГ 3 ШИЛЭН ДАНСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУД ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ХЭДИЙ Ч ЗӨРЧИЛ ДАВТАГДСААР БАЙНА. _____	12
Аудитын дүгнэлт _____	15
Аудитын зөвлөмж _____	16
Холбогдох байгууллагын санал _____	17
Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар _____	18
Аудитын тайлан баталгаажуулсан тушаал _____	20

¹ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж байгууллага

² Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуй нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОБХ	Онцгой байдлын хэлтэс
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХАА	Санхүүгийн хяналт аудитын алба
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УЦУОШГ	Ус цаг уур орчны шинжилгээний газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААГ	Хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХО	Хөрөнгө оруулалт
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2019 оны А/03 тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 оны аудитын төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийлээ. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1³, 3.1.2⁴–т байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3⁵, 3.1.4⁶, 3.1.5⁷-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.5 дахь хэсэгт заасан хуулийн этгээд, төрийн байгууллагууд хуульд заасан мэдээллийг 2018 оны байдлаар шилэн дансны нэгдсэн системд мэдээлсэн байдалд аудит хийж гүйцэтгэлээ.

³ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

⁴ Төрийн өмчит үйлдвэрийн газар

⁵ Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани

⁶ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж байгууллага

⁷ Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, МУЕА-ын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан, аймаг, сумдын ЗДТГ, СТСХ болон холбогдох хэлтсийн албан тушаалтантай ярилцах, санал асуулга авах, дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөөг тайлантай тулгах, баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам.

Аудитын хугацаа, бүрэлдэхүүн:

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа хянан удирдаж, аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналтыг хэрэгжүүлж, нийцлийн аудитын багийн аудитор Б.Уранбилэг, Т.Мөнхтогтох нар гүйцэтгэв.

1 БҮЛЭГ: ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН СИСТЕМД УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУД БҮРЭН ХАМРАГДСАН Ч ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН ОРУУЛАХ АЖИЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан зарим заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Тус аймагт хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан нийт 173 байгууллага төрийн чиг үүргийг хэрэгжүүлэн, үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр байгууллагууд бүгд шилэн дансны нэгдсэн системд цахим хуудас нээлгэсэн байна. /Хүснэгт №1/

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах байгууллагын тоо


/Хүснэгт №1/

№	Үзүүлэлт	Байгууллагын тоо	Шилэн дансны нэгдсэн системд цахим хуудас нээлгэсэн байгууллагын тоо
1	Улсын төсвийн байгууллага	35	35
2	Орон нутгийн төсвийн байгууллага	117	117
3	ОНӨААТҮГ, ОНӨҮГ	2	5
4	ТТЗ, ТЕЗ	15	15
5	Төрийн өмчит үйлдвэрийн газар	4	4
Нийт дүн		173	173

Тайлант онд Дорноговь аймаг дахь Улсын нөөц, Айраг суман дахь Улсын нөөцийн салбарууд аймгийн ОБХ-тэй нэгдсэнээр цахим хуудсууд устгагдаж, ОНБ-ийн үндсэн цахим хуудсанд мэдээллийг оруулсан байна. Харин Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба шилэн дансны нэгдсэн системд шинээр цахим хуудас нээсэн байна.

Мөн аудитад төрийн нууцын зэрэглэлтэй Сайншанд, Замын-Үүд суман дахь Тагнуулын хэлтэс, Хилийн цэргийн 0108,0129,0168-р анги, Зэвсэгт хүчний 253, 090, 281, 336-р ангиудыг хамруулаагүй. Мөн Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрыг Үндэсний аудитын газраас шалгах тул аудитад хамруулаагүй болно.

Аудитад хамрагдсан дээрх байгууллагууд хуульд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн систем дэх өөрийн цахим хуудсаар мэдээлж байна. Харин Замын-Үүд сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэг нь байгууллагын цахим хуудсанд нэвтэрч, мэдээллийг оруулдаг боловч гадна хандалтаар харагдахгүй, хайлтаар илэрцгүй байна.



Аудитаар хуулийн 3.1.1-3.1.2-т хамаарах байгууллагуудын шилэн дансанд мэдээлсэн мэдээллийг холбогдох нотлох баримттай тулган шалгахад дараах байдалтай байна.

Үүнд:

- Хуулийн 6.1.1-д заасан тухайн жилийн төсвийг 9 байгууллага буюу 5.2 хувь нь мэдээлээгүй
- Хуулийн 6.1.2-т заасан хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг 7 байгууллага буюу 4 хувь нь мэдээлээгүй
- Хуулийн 6.1.3-т заасан дараа жилийн төсвийн төслийг 32 байгууллага буюу 18,4 хувь нь мэдээлээгүй
- Хуулийн 6.1.4-т заасан хагас жилийн санхүүгийн тайланг 17 байгууллага буюу 9.8 хувь нь мэдээлээгүй
- Хуулийн 6.1.5-т заасан аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 32 байгууллага буюу 18.4 хувь нь мэдээлээгүй
- Хуулийн 6.1.6-д заасан төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 75 байгууллага буюу 43,4 хувь нь мэдээлээгүй зөрчилтэй байна.

Мөн хуулийн 6.1.1⁸-д заасан мэдээллийг Аймгийн ТЭЗ болон сумын ТТЗ тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ОНХС-ийн төлөвлөлтийг хуулийн хугацаанд мэдээлж, Дэлгэрэх, Сайхандулаан, Эрдэнэ сумын ТТЗ нар мэдээлээгүй байна.

Хуулийн 6.1.2⁹-т заасан мэдээллийг үзэхэд төсвийн гүйцэтгэлийн мэдээг байгууллагууд мэдээлж хэвшсэн хэдий ч зарим байгууллагууд сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаа хоцроох, мэдээлсэн мэт харагдах боловч мэдээллийг бүрэн гүйцэд оруулаагүй, огт мэдээлээгүй зэрэг зөрчил илэрч байна. Тухайлбал:

- Замын-Үүд сумын Цагдаагийн хэлтэс 2018 оны 3 дугаар сарын мэдээг мэдээлээгүй
- Алтанширээ сумын 2018 оны 1-6, 8-9 дүгээр сарын мэдээг мэдээлээгүй
- Алтанширээ сумын ИТХ 2018 оны 1-6, 8-9 дүгээр сарын мэдээг мэдээлээгүй
- Алтанширээ сумын ТТЗ 2018 оны 1-9 дүгээр сарын мэдээг мэдээлээгүй
- Сайхандулаан сумын ТТЗ 2018 оны 8-9 саруудын мэдээг мэдээлээгүй, 1-7 саруудын мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн.
- Сайхандулаан сумын ИТХ 2018 оны 2-3, 8 дугаар сарын мэдээг мэдээлээгүй, 6, 9 дүгээр сарын мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчлүүд байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4¹⁰-д заасан мэдээллийг дараах байгууллагууд хуулийн хугацаанд мэдээлээгүй байна.

Тухайлбал:

- Хуулийн 6.4.1-д заасан тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг Сайхандулаан сумын ТТЗ мэдээлээгүй байна.
- Хуулийн 6.4.2-т заасан тухайн байгууллагын төлбөр хураамжтай холбоотой мэдээллийг Тохижилт Сайншанд хот тохижилтын газар мэдээлээгүй байна.
- Хуулийн 6.4.3-т заасан тендер худалдан авалттай холбоотой мэдээллийг 8 байгууллага буюу нийт байгууллагын 4 хувь мэдээлээгүй байна.
- Хуулийн 6.4.6-д худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан дүгнэлтийг мэдээлвэл зохих ТЭЗ болон ТТЗ нараас Замын-Үүд, Сайхандулаан сумдын ТТЗ нар мэдээлээгүй байна.
- Хуулийн 6.4.7-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг Дорноговь АЗЗА ТӨХК мэдээлээгүй байна.

⁸ тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ОНХС-ийн төлөвлөлтийг жил бүрийн 10-ны дотор

⁹ хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны дотор, сар улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны дотор

¹⁰ төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд 7 хоногийн дотор мэдээлэх

Мөн тайлант хугацаанд хуулийн 6.4.4-т¹¹ заасан мэдээллийг шалгахад мэдээлэх ёстой 729 гүйлгээнээс 18 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь мэдээлэх ёстой мэдээллийн 97.5 хувийг мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-ийг мэдээлнэ гэж заасан байна.

Аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн /3.1.1, 3.1.2/ үйлчлэлд хамаарах улс, орон нутгийн төсвийн 173 байгууллагад нийт 787081.0 сая төгрөгийн мөнгөн дүн бүхий орлогын 6192 гүйлгээ, 754476.4 сая төгрөгийн мөнгөн дүн бүхий зарлагын 3177 гүйлгээ гарсан байна. /Хүснэгт №2/

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг мэдээлсэн байдал

Хүснэгт №2

Үзүүлэлт	Мэдээлэх ёстой гүйлгээ		Мэдээлсэн гүйлгээ		Мэдээлээгүй гүйлгээ		Мэдээлсэн хувь
	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/	
Орлого	6192	787081	6028	782997	164	4084	97%
Зарлага	3177	754476.4	2491	753391.5	686	1084.9	78%

Дээрх хүснэгтээс харахад орлогын гүйлгээний мэдээллийн 3 хувийг, зарлагын гүйлгээний мэдээллийн 22 хувийг мэдээлээгүй байна.

Мөн хуулийн 6.4.8-д “ ... төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг мэдээлнэ” гэж заасан байна. /График №1/

Тайлант хугацаанд хамрагдсан байгууллагад нийт 35596.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 3585 шийдвэр гарсан байна. Хэрэгжилтийг графикаар дүрсэлбэл дараах байдалтай байна.




Тушаал, шийдвэр мэдээлээгүй зарим байгууллагыг дурдвал:

- Эрүүл мэндийн газар 642.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 25 тушаал,
- ШШГА 25.9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 10 тушаал
- ХХҮГ 48.9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 12 тушаал
- ХЭДС-ийн 189.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 18 тушаал
- Дэлгэрэх сумын ЗДТГ 148.9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 12 тушаал
- Сайхандулаан сумын ИТХ 75.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 20 тушаал
- Алтанширээ сумын ЕБС 24 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 14 тушаал

¹¹ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг

- Эрдэнэ сумын ЕБС 47.4 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 20 тушаал
- Сайншанд сумын ТТЗ 1085.3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 41 захирамж
- Дэлгэрэх сумын ТТЗ 86.3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 13 захирамж
- Хөвсгөл сумдын ЗДТГ 26.6 сая төгрөгийн 13 тушаал мэдээлээгүй байна.
- Иххэт сумын ТТЗ 87.1 сая төгрөгийн 9 захирамж мэдээлээгүй байна
- Замын-Үүд сумын ТТЗ 747.7 сая төгрөгийн 14 захирамж мэдээлээгүй байна

Мөн Сайншанд сумын ТТЗ-ийн цахим хуудас нь 4 нэвтрэх эрхтэй, эдгээр эрхээр ямар мэдээллийг хэн мэдээлэх нь тодорхой бус байгаагаас сумын Засаг даргын захирамж, шийдвэрийг 2018 оны 2-3 дугаар улиралд огт мэдээлээгүй, 4 дүгээр улиралд дутуу мэдээлсэн байна. Өмнөх аудитаар нэвтрэх эрхийн зохион байгуулалтыг хийх тухай зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.



Үүний зэрэгцээ Дэлгэрэх сум ТТЗ-ийн шилэн дансны мэдээллийг үзэхэд 2018 оны 12 сар болон бүтэн жилээр мэдээлэх мэдээллийг мэдээлээгүй байна.

Дэлгэрэх сумын ТТЗ-ийн 2018 оны Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдал.

Иймд дээрх дурдсан болон судалгаагаар хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй байгууллага, албан тушаалтанд холбогдох зөвлөмж, албан шаардлага тогтоохоор шийдвэрлэв.

1.2 Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг санхүүгийн мэдээллийн самбартаа мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлд “байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх, мөн орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заасан.

Үүний дагуу аймгийн ЗДТГ, ЭМГ, МХГ, Цагдаагийн газар, Шүүхийн Тамгын газар, ШШГГ, УЦУОШГ, ХХҮГ, ГХБХБГ, МСҮТ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Сайншанд сумын ЗДТГ, Замын-Үүд сумын ЗДТГ, Замын-Үүд сумын Цагдаагийн хэлтэс, Замын-Үүд дэх Гаалийн газар байгууллагын цахим хуудсандаа шилэн дансны бие даасан цэстэй, цэсээр ороход shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсанд холбогдож, тухайн байгууллагын шилэн дансны мэдээлэл гарч ирдэг байна.

Харин аймгийн ЗДТГ, ШШГГ, УЦУОШГ, ХХҮГ, МСҮТ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Замын-Үүд Цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагын цахим хаягт байгаа “Шилэн данс” цэсээр нэвтрэхэд мэдээлэл байхгүй, алдаа зааж байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5.1.”Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна, 5.1.2.мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх;.....” гэсэн заалтыг зөрчиж байна. Иймд холбоосыг зөв татуулж мэдээллийг хэвийн харагддаг болгох шаардлагатай байна.

Аймаг, сумын төсөвт байгууллагууд байгууллагын мэдээллийн самбараас гадна санхүүгийн мэдээллийн самбарт төсөв төлөвлөгөө, хууль тогтоомж, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, сарын мэдээг байршуулж мэдээлсэн байна.

2 БҮЛЭГ: ХУУЛИЙН 3.1.4¹², 3.1.5¹³-Д ХАМААРАХ БАЙГУУЛЛАГУУД “ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ-ууд шилэн дансны нэгдсэн системд цахим хуудас нээлгээгүй, холбогдох мэдээллийг мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 9-д “ арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, ... төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа ААНБ-ууд нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай бол олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно” гэж заасан байна.

Аудитын хамрах хугацаанд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа нийт 160 ААНБ, нөхөрлөл, иргэн байна. /Хүснэгт №3/

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ, нөхөрлөл, иргэн

/Хүснэгт №3/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Гүйцэтгэгч ААНБ, нөхөрлөл, иргэний тоо
1	Замын сангийн ХО	6
2	Аймаг, сумын ХО	50
3	Аймаг, сумын ОНХС	92
4	УТХО	8
Нийт		156

¹² Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж байгууллага



¹³ Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч

Хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжүүлсэн Эрдэнэ, Дэлгэрэх, Сайхандулаан сумдын ТТЗ нар шилэн дансны цахим хуудсанд гүйцэтгэгчийг мэдээлээгүй байна. Харин бусад сумд болон аймгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг холбогдох төрийн байгууллагууд, ТЕЗ, ТТЗ нар энэхүү мэдээллийг улирал бүр мэдээлсэн байна.



Дээрх мэдээллийг байршуулаагүй Эрдэнэ, Дэлгэрэх, Сайхандулаан сумдын ТТЗ нарт хуулийг хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Харин хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэгч хувийн ААНБ-ын хувьд шилэн дансны нэгдсэн системд байгууллагын цахим хуудас нээгээгүй, мэдээлэл байршуулаагүй байна. Тухайлбал: /түүвэрлэн хамруулав/



- ОНТХО-аар Айраг сумын ЭМТ-ийн өргөтгөлийн ажил гүйцэтгэсэн Дархан харуул ХХК шилэн дансны нэгдсэн системд цахим хуудас үүсгээгүй, байгууллагын бие даасан website байхгүй.





- АОНХС, ОНТХО-аар Эрдэнэ сумын төвийн ААНБ, айл өрхийг нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны шугамд холбох ажлын гүйцэтгэгч СИЗУ ХХК шилэн дансны нэгдсэн системд цахим хуудас үүсгээгүй, байгууллагын бие даасан website байхгүй.



- УТХО-ын хөрөнгөөр ХХААГ-ын авто гражийн дээвэр хаалгыг шинэчлэх ажлын гүйцэтгэгч Сайншанд өргөө ХХК шилэн дансны нэгдсэн системд цахим хуудас үүсгээгүй, байгууллагын бие даасан website байхгүй.



- Замын сангийн хөрөнгөөр Сайншанд сумын 2-р цэцэрлэгийн авто зогсоол барих ажлын гүйцэтгэгч Дэлгэрэх баясах зам ХХК шилэн дансны нэгдсэн системд цахим хуудас үүсгээгүй, байгууллагын бие даасан website байхгүй.



Харин Чандмань Илч ОНӨХХК, АЗЗА ТӨХК, Чандмань бадрал ОНӨХХК зэрэг орон нутгийн болон төрийн өмчит байгууллагууд шилэн дансны нэгдсэн системд цахим хуудастай боловч хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй байна. Учир нь тухайн байгууллагын өөрийн төсвийн хүрээнд зохион байгуулагдах ХАА-ны мэдээлэл байршуулах цэстэй боловч бусад эх үүсвэрээр санхүүжсэн ажлын хувьд мэдээлэл оруулах цэс байдаггүйтэй холбоотой байна.

2.2 Хуулийн 3.1.5-д хамаарах байгууллагууд Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 9-д “... арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага нь төсөл, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийн явц, үе шат зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу мэдээллээ улирал бүр мэдээлнэ” гэж заасан байна.

Тус аймгийн хэмжээнд хуулийн 3.1.5-д хамаарах 11 ААНБ үйл ажиллагаа явуулж байна. /Хүснэгт №4/

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага

/Хүснэгт №4/

№	ААНБ-ын үзүүлэлт	Тоо	Шилэн дансны нэгдсэн системд цахим хуудас нээлгэсэн
1	Өрхийн Эрүүл мэндийн төв	5	5
2	Ерөнхий боловсрол олгох сургууль	1	1
3	Хүүхдийн цэцэрлэг	4	4
4	МСҮТ	1	1
Нийт		11	11

Эдгээр байгууллагуудын шилэн дансны нэгдсэн систем дэх цахим хуудсанд мэдээлсэн мэдээллийг холбогдох баримттай тулган шалгалаа.

Хуулийн 6.9-д заасны дагуу дээрх байгууллагууд шилэн дансны нэгдсэн системд зөвхөн 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээний талаар мэдээлэх ёстой. Сайншанд сумын Агатова ӨЭМТ, Талст зам ӨЭМТ, Гоёо мэнд ӨЭМТ, Мишээлт мана ӨЭМТ, Замын-Үүд сумын Борхойн наран ӨЭМТ-үүд хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

Харин Замын-Үүд сумын Ухаалаг багачууд, Жаргалан, Гурван билэг, Болор-Эрдэнэ цэцэрлэгүүд, Үлэмж тэнгэр ерөнхий боловсролын сургууль, Сайншанд сумын Төмөр замын МСҮТ гэсэн эдгээр ААНБ-ууд шилэн дансны цахим хуудсаа хөтлөөгүй, мэдээлэл огт оруулаагүй, хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байсан тул холбогдох албан тушаалтанд хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3 БҮЛЭГ: ШИЛЭН ДАНСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУД ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ХЭДИЙ Ч ЗӨРЧИЛ ДАВТАГДСААР БАЙНА.

3.1 Аймгийн ИТХ-аас шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

2018 онд Шилэн дансны тухай хуулийн 8.1¹⁴-д заасны дагуу Аймгийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2018 оны 46 дугаар тогтоолоор улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2016-2018 онд хийгдсэн, хийгдэж байгаа ажлуудын гүйцэтгэл, үр дүнд хөндлөнгийн шалгалтыг хурлын хороодоос хамтран зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна. Энэхүү ажлын хүрээнд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, аймгийн ИТХ-аар хэлэлцэн холбогдох чиг үүргийг аймгийн Засаг дарга болон сумдын ИТХ-д хүргүүлсэн байна. Шилэн дансны цахим хуудсанд нийт 8532 мэдээлэл мэдээлэхээс 7535 мэдээллийг хугацаанд нь, 997 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлснийг шалгалтаар илрүүлж хуулийн хэрэгжилтийг 88 хувьтай байна гэж дүгнэжээ.

Мөн АИТХ-ын зүгээс сумдын ИТХ-ын шилэн дансны нэгдсэн системд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж сумдыг 28.5-100 хүртэл хувиар дүгнэсэн байна. Дүнгийн нэгтгэлээр Дэлгэрэх сумын ИТХ хамгийн бага буюу 28.5 хувь, Айраг сумын ИТХ хамгийн өндөр буюу 100 хувь гэсэн үнэлгээг авсан байна. Тус нэгтгэлээр Сайншанд, Замын-Үүд сумдын ИТХ хамрагдаагүй байна.

3.2 Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, тодорхой арга хэмжээ авч ажилласан байна.

¹⁴ энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ

Шилэн дансны тухай хуулийн 8.2¹⁵, Төсвийн тухай хуулийн 69.1¹⁶, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 8 дугаар хэсгийн 8.5¹⁷-д тус тус заасны дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллахаар заасан байна.

Дорноговь аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах 148 байгууллагын шилэн дансны үйл ажиллагаанд 2019 оны 1-2 дугаар саруудад дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Тус шалгалтаар нийт хамрагдсан байгууллагаас 19462 мэдээллийг цахим хуудсанд мэдээлэхээс 16654 мэдээллийг хугацаанд нь, 2593 мэдээллийг хугацаа хоцроож, 215 мэдээллийг огт мэдээлээгүй дүнтэй гарсан байна. Мөн 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар Сангийн яаманд шилэн дансны тайланг 116 байгууллага хүргүүлж, 31 байгууллага илгээгүй зөрчил илэрсэн байна. Шалгалтаар илэрсэн зөрчилд аймгийн Засаг даргад цаашид авах арга хэмжээний саналыг хүргүүлсэн ба уг саналд нэр бүхий сум, байгууллагуудын төсвийн захирагч, санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч нарт зөрчлийн шинж байдлыг харгалзан “Төрийн албаны тухай хууль”-д заасны дагуу хариуцлага тооцох саналыг хүргүүлсэн байна.

3.4 Шилэн дансны мэдээлэлтэй иргэд олон нийт хэрхэн танилцаж, мэдээллийн ач холбогдолтой эсэхийг хянах боломжгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага албан тушаалтан хүлээн авахгүй бол энэ талаарх гомдол мэдээллийг иргэн, хуулийн этгээд ... төрийн аудитын байгууллагад гаргах ...” гэж заасан байна.

2018 онд иргэд, ААНБ-аас “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилттэй холбоотой өргөдөл, гомдол, санал хүсэлт гараагүй байна.

Мөн тайлант 2018 онд иргэн, ААНБ-аас уг хуулийн хэрэгжилттэй холбоотой санал, гомдлыг Төрийн аудитын газарт гаргаагүй.

Иргэд шилэн дансны цахим хуудсанд хандаж, хэрхэн мэдээлэл авч байгааг хөндлөнгийн аудитын эрхээр нэвтэрч хянаж үзэхэд тус цахим системийн хандалтын тоог мэдэх боломжгүй, харагдах байдал байхгүй байв.

ААНБ, иргэдээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой санал, гомдлыг олон нийтийн цахим сүлжээ болох Засгийн газрын <https://11-11.mn/>, Дорноговь аймгийн www.dornogovi.gov.mn сайтад ирүүлээгүй байна.

Хуулийн этгээд, иргэдийн санал, гомдолд үндэслэн иргэд, ААНБ-аас уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллийг ашиглаж байгааг тогтоох боломжгүй байна.

¹⁵ энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ

¹⁶ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

¹⁷ Төсвийн ерөнхийлөн захирагч (дотоод аудитын алба)

3.4 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт 87 хувьтай, зөвлөмжийн хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сэдэвт аудитыг 2017 оны 4 дүгээр улирлаас 2018 оны 1-3 дугаар улирлын байдлаар хийж гүйцэтгэсэн. Аудитаар аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, Сайншанд сумын Засаг дарга нарт нийт 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Эдгээр зөвлөмжийн хэрэгжих хугацаа 2019 оны 6 дугаар сарын 30 учир хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй байна.

Мөн дээрх аудитаар нийт 23 байгууллагад хууль хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлагыг хүргүүлж, Сайхандулаан сумын ТТЗ, ЗДТГ, ИТХ-аас албан шаардлагын хэрэгжилтийг ирүүлээгүй байна. Тогтоосон албан шаардлагын хэрэгжилт 87 хувьтай байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Улс, орон нутгийн төсвийн байгууллагууд шилэн дансны цахим системд бүрэн хамрагдаж мэдээллийг цахимаар болон мэдээллийн самбараар хуульд заасан мэдээллийг мэдээлсэн байна.
- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн зарим заалтуудын хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхийн орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай гарсан тушаал шийдвэрийг бүрэн мэдээлээгүй байна.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ талаарх мэдээллийн төсвийн байгууллагууд мэдээлж байгаа боловч гүйцэтгэж байгаа ААНБ-ууд шилэн дансанд цахим хуудас нээлгээгүй, холбогдох мэдээллийг мэдээлээгүй байна.
- Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч Замын-Үүд сумын хувийн өмчит 1 сургууль, 4 цэцэрлэг, Сайншанд сумын Төмөр замын МСҮТ зэрэг байгууллагууд хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.
- Шилэн дансны үйл ажиллагаанд Аймгийн ИТХ болон СХАА-аас хяналт шалгалт хийж, холбогдох санал зөвлөмж, чиглэлийг хүргүүлсэн байна.
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт 87 хувьтай, мөн зөвлөмжийн хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Дараах нь саналыг Сангийн яаманд уламжилж өгнө үү. Үүнд:

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газраас:

1. Шилэн дансны нэгдсэн системд гаднаас хандах хандалтын тоог харах үзүүлэлт цэс нэмэх.
2. ОНӨХХК, ТӨХК-аас ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу ОНТХ, ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэсэн тухай мэдээлэл оруулах цэс нэмэх.

Дорноговь аймгийн ЗДТГ-аас:

1. Шилэн дансны мэдээллийн системд байршуулах мэдээний тоо, нэр төрлийг хураангуй болгож, иргэдэд ойлгомжтой энгийн байлгах.
2. Системийн ачаалал, доголдлоос хамаарч үүсэх хүндрэлийг арилгуулах.
3. Санхүүгийн программын үйл ажиллагааг шилэн дансны системтэй уялдуулах.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Т.ЭНХТҮВШИН ТАНАА

1. Шилэн дансны тухай хуулийн 8.4-т “Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.СОДХҮҮ ТАНАА

1. Улс, орон нутгийн төсвийн байгууллагуудын удирдах албан тушаалтан, нягтлан бодогч нарт “Шилэн дансны тухай хууль”-ийг хэрэгжүүлж ажиллах, арга зүйн заавар, зөвлөмжөөр хангах.

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГА С.ОДБАЯР ТАНАА

1. Сайншанд сумын ТТЗ-ийн шилэн дансны нэгдсэн систем дэх цахим хуудсанд нэвтрэх албан тушаалтан, тэдгээрийн чиг үүргийг тодорхой болгож, мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон,
Утас/факс: (705) 2-30-03

E-mail: dornogovi_mgl@yahoo.com

2019.04.10 № 3/643
танай 2019.04.09 -ны № 1-6/394 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Ч.АРИУНАА ТАНАА

Төрийн аудитын газрын 2018 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн тайлангийн төсөлд дараах саналыг оруулах хүсэлтэй байна. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны мэдээллийн системийн доголдол үүссэн нөхцөл байдлыг харгалзан үзэж байх.
2. Шилэн дансны мэдээллийн системд байршуулах мэдээний тоо, нэр төрлийг хураангуй болгож иргэдэд ойлгомжтой энгийн байлгах.
3. Системийн ачаалал, доголдлоос хамаарч үүсэх хүндрэлийг арилгуулах.
4. Санхүүгийн програмын үйл ажиллагааг шилэн дансны системтэй уялдуулах гэсэн саналуудыг хургуулж байна.

ДАРГА

Б.ГАНЗОРИГ

44 8 10490

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 3/643 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг ҮАГ-ын Сангийн яаманд уламжлахаар зөвлөмж хэсгийн 1-р хэсэгт оруулав.

НИЙЦЛИЙН АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АУДИТОР

Б.УРАНБИЛЭГ

АУДИТОР

Т.МӨНХТОГТОХ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЛҮНДЭГМАА

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД

ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЬЕ.

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/08

Дорноговь аймаг, Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйл, 19 дүгээр зүйлийн 19.3.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаал, Ерөнхий аудиторын 2018 оны А/207 тоот тушаалын V хавсралтын 2.4, "Нийцлийн аудитын түр журам"-ын 09 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс болон Сайншанд сумын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
5. Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгчид үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА